



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМНЫ  
ДЭРГЭДЭХ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ**

2023 оны 01 сарын 24 өдөр


Дугаар 1

Улаанбаатар хот

**Төлөвлөгөө батлах тухай**

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.2, 4.1.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн “Төрийн албаны зөвлөлийн Эдийн засаг, хөгжлийн яамны дэргэдэх Салбар зөвлөлийг байгуулж, бүрэлдэхүүнийг томилох тухай” 598 дугаар тогтоолын 3 дахь хэсгийг үндэслэн тус тус ТОГТООХ нь:

1. Төрийн албаны зөвлөлийн Эдийн засаг, хөгжлийн яамны дэргэдэх Салбар зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
2. Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг тогтоосон хугацаанд, үр дүнтэй хэрэгжүүлэн ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Эдийн засаг, хөгжлийн яамны дэргэдэх Салбар зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.
3. Төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Эдийн засаг, хөгжлийн яамны дэргэдэх Салбар зөвлөлийн гишүүн /Х.Оюунцэцэг/-д даалгасугай.



САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

И.БАТХҮҮ

230001

Төрийн албаны зөвлөлийн Эдийн засаг, хөгжлийн яамны дэргэдэх Салбар зөвлөлийн 2023 оны 4 дугаар сарын 1-ны өдрийн 4 дугаар тогтоолын хавсралт

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

ДД	Үйл ажиллагаа	Хугацаа	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцах албан тушаалтан
1.	Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулахтай холбогдсон арга зүйн зөвлөгөө өгөх	Жилдээ	Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах талаар шаардлагатай мэдээлэл зөвлөгөөг өгч, нийт албан хаагчдад 2 удаагийн сургалт зохион байгуулж ажилласан байна.	Эдийн засаг, хөгжлийн яамны дэргэдэх Салбар зөвлөлийн гишүүд
2.	Салбар зөвлөлийн тайлан мэдээг тогтоосон хугацаанд нэгтгэн гаргаж, Төрийн албаны зөвлөлд хүргүүлэх	II, IV улирал	Тайлан, мэдээг хугацаанд нэгтгэн гаргаж, хүргүүлсэн байна.	Эдийн засаг, хөгжлийн яамны дэргэдэх Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга
3.	Салбар зөвлөлийн үйл ажиллагааг таниулан сурталчлах чиглэлээр Яамны цахим хуудаснаа Төрийн албаны зөвлөлийн Эдийн засаг, хөгжлийн яамны дэргэдэх салбар зөвлөлийн мэдээллийг цаг тухайд нь шинэчилж, ил тод байдлыг хангах	Тухай бүр	Төрийн албаны зөвлөлийн Эдийн засаг, хөгжлийн яамны дэргэдэх салбар зөвлөлийн үйл ажиллагаа хэрэгжилт, үр дүн сайжирч, нийтэд ил тод мэдээлэлтэй болсон байна.	Эдийн засаг, хөгжлийн яамны дэргэдэх Салбар зөвлөлийн гишүүд; Эдийн засаг, хөгжлийн яамны дэргэдэх Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга

4.	Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албан тушаалд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон маргааныг хүлээн авч, маргаан хянан шалгах комиссын үүрэг даалгаврын дагуу асуудлыг шалгах, холбогдох баримт материалыг бүрдүүлэх, холбогдох этгээдээс тайлбар авах ажлыг зохион байгуулах	Тухай бүр	Холбогдох этгээдээс тайлбар авах, баримт материалыг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах.	Эдийн засаг, хөгжлийн яамны дэргэдэх Салбар зөвлөлийн гишүүд
5.	Холбогдох хууль, тогтоомж, журамд нийцүүлэн ажлын байрны сул орон тоог нээлттэй ил тод зарлаж, тусгай шалгалтыг зохион байгуулж, төрийн албан хаагчдыг томилох зэргээр хүний нөөцийг бүрдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах	Жилдээ	Холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд нийцүүлэн тусгай шалгалтыг ил тод нээлттэй байдлыг ханган зохион байгуулж, хүний нөөцийг бүрдүүлсэн байна.	Эдийн засаг, хөгжлийн яамны дэргэдэх Салбар зөвлөлийн гишүүд
6.	Яамны албан хаагчдад албан тушаалын зэрэг дэв олгох саналыг нэгтгэн боловсруулах	12 дугаар сард	Журамд заасан шаардлага хангасан албан хаагчдад зэрэг дэв олгох саналыг гаргасан байна.	Эдийн засаг, хөгжлийн яамны дэргэдэх Салбар зөвлөлийн гишүүд, нарийн бичгийн дарга
7.	“Төрийн албаны тэргүүний ажилтан” тэмдгээр шагнуулах албан хаагчийг тодруулж, Эдийн засаг, хөгжлийн яамны дэргэдэх Салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, саналыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлэх	II, IV улирал	Яамны газар, хэлтсээс нэр дэвшүүлсэн албан хаагчдыг Эдийн засаг, хөгжлийн яамны дэргэдэх Салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, шалгарсан албан хаагчийн материалыг холбогдох журмын дагуу бүрдүүлж, Төрийн албан зөвлөлд хүргүүлсэн байна.	Эдийн засаг, хөгжлийн яамны дэргэдэх Салбар зөвлөлийн гишүүд

8.	Төрийн албаны зөвлөлөөс гаргасан шийдвэр, өгсөн үүрэг хэрэгжилтийг ханган ажиллах, тайлагнах	Тухай бүр	Төрийн албаны зөвлөлөөс гаргасан шийдвэр, өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг зохион байгуулж, тайлагнасан байна.	Эдийн засаг, хөгжлийн яамны дэргэдэх Салбар зөвлөлийн гишүүд, нарийн бичгийн дарга
----	--	-----------	---	--

--oOo--